
МХБ-ийн ТУЗ-ийн 2014 оны 12 дугаар сарын
30-ны өдрийн 2014/16 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮНЭТ ЦААСНЫ ИНДЕКС ТООЦОХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар Монголын хөрөнгийн бирж (цаашид МХБ гэх)-д бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны индекс тооцох үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журамд орсон нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1 Индекс - тухайн индекс тооцох багцад орсон үнэт цааснуудын үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлт;
 - 1.2.2 Зах зээлийн үнэлгээ (цаашид ЗЗҮ гэх) - Тухайн хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тооноос төрийн эзэмшилд байгаа хувь хэмжээг хорогдуулан гаргасан хувьцааны тоо ширхгийг буюу олон нийтэд чөлөөтэй арилжих хувьцааны тоо ширхгийг тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшаар үржүүлж гаргасан үзүүлэлт;
 - 1.2.3 Хаалтын ханш – тухайн арилжааны өдөр хийгдсэн бүх арилжааны тоо хэмжээний жигнэсэн дундаж ханшаар тооцоолсон ханш;
 - 1.2.4 Арилжааны өдрийн дундаж гүйлгээ -Тухайн үнэт цаасны хагас жил тутамд арилжигдсан гүйлгээний үнийн дүнг (багцын арилжааг оруулахгүй) тухайн хугацаанд арилжаа явагдсан өдрийн тоонд харьцуулж гаргасан үзүүлэлт;
 - 1.2.5 Тохируулах коэффициент буюу Adjustment factor (Adj) - Тухайн хувьцаат компанийн олон нийтэд чөлөөтэй арилжих хувьцааны тоо ширхгийг тухайн компанийн нийт гаргасан үнэт цаасанд нөлөөлүүлэх үзүүлэлт.
- 1.3 МХБ нь Нэгдсэн (MSE ALL) болон ТОП-20 индексүүдийг тооцох ба индексийг арилжааны программыг ашиглан үнэт цаасны арилжаа явагдсан өдөр бүр тооцно.
- 1.4 Энэхүү журамд МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хоёр. ИНДЕКСИЙН БАГЦАД ОРОХ ХУВЬЦААТ КОМПАНИЙГ ШАЛГАРУУЛАХ АРГАЧЛАЛ

- 2.1 ТОП-20 индексэд энэхүү журмын 2.3 дугаар зүйлд заасан шалгуур хангасан, МХБ-д бүртгэлтэй 20 компани орно.
- 2.2 ТОП-20 индексийн багцыг жил бүрийн эхний хагас жил болон сүүлийн хагас жилийн арилжааны мэдээн дээр үндэслэн 1 дүгээр болон 7 дугаар сарын эхний ажлын 10-н өдөрт багтаан шинэчлэн тогтооно.

2.3 ТОП-20 индексийн багцад орох компанийг дараах аргачлалаар бүрдүүлнэ. Үүнд:

- 2.3.1 Хагас жил бүрээр тухайн төрлийн бүртгэлтэй бүх компанийг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ гэсэн 2 үзүүлэлтээр байр эзлүүлнэ.
- 2.3.2 Дээрх 2 үзүүлэлтийн хувьд тухайн компанийн эзэлсэн байраас аль ихийг нь сонгон дахин байр эзлүүлнэ. Энэхүү байр эзлүүлэлтээр хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан компаниудыг индекс тооцох багцад сонгон авна.
- 2.3.3 Хэрэв 2 компанийн үзүүлэлт ижил байвал зах зээлийн үнэлгээ өндөртэй компанийг сонгон авна.
- 2.3.4 Индексийн багцад орох компанийн үнэт цаас нь МХБ-ийн үнэт цаасны арилжааны хоёрдогч зах зээлд хагас жилийн нийт арилжааны өдрийн 20 хувиас доошгүй өдөрт арилжигдсан байна.
- 2.3.5 МХБ-ийн Захирлын зөвлөл нь МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр индексийн багцад орох компанийн жагсаалтад байр урагшлуулах, байр ухраах, индексийн багцаас хасах, индексийн багцад оруулах гэх мэт шийдвэрийг хугацаа харгалзахгүй батлан хэрэгжүүлж индексийн багцад өөрчлөлт оруулна.

2.4 МХБ-ийн Нэгдсэн индексийн сагсанд МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэлтэй, үнэт цаас нь олон нийтэд арилжигддаг хувьцаат компаниудын үнэт цаас орно.

Гурав. ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ

3. Индекс тооцохдоо дараах аргачлалыг баримтлана. Үүнд:

3.1 Индексийн багцад орсон хувьцаат компани бүрээр түүний тохируулах коэффициентийг (1) томъёогоор тооцно.

$$(1) Adj_n = \frac{Sharequantity_{n, free-float}}{IQ_n} * W_n$$

- Adj_n – n хувьцаат компанийн тохируулах коэффициент,
- $Share quantity_{n, free-float}$ – n компанийн олон нийтэд чөлөөтэй арилжих хувьцааны тоо ширхэг,
- IQ_n - тухайн хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг буюу Issued quantity,
- W_n – n хувьцаат компанийн индексэд үзүүлэх нөлөөг хязгаарлагч

3.1.1 $Share quantity_{n, free-float}$ буюу тухайн компанийн олон нийтэд чөлөөтэй арилжих хувьцааны тоо ширхэг. Үүнийг тооцохдоо тухайн хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны тоо ширхгээс төрийн эзэмшилд буй хувьцааны тоо ширхэгийг хасч тооцно.

3.2 W_n буюу тухайн хувьцаат компанийн индексэд үзүүлэх нөлөөг хязгаарлагч нь 0,0000-оос 1,0000-ийн хооронд, таслалын дараа дөрвөн орон бүхий утгатай байна.

3.3 W_n үзүүлэлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтлана.

3.3.1 Тухайн ХК бүрийн индексийн тооцоонд ашиглагдах зах зээлийн

үнэлгээ (2), түүний ЗЗҮ-нийх нь сагсан дахь нийт компанийн дунд эзлэх хувь (3)-ийг тус тус дараах томъёоны дагуу олно.

$$(2) \quad \text{Cap}_n = \sum P_n * Q_n ;$$

$$(3) \quad w_n = \frac{\text{Cap}_n}{\sum \text{Cap}}$$

Cap_n - n компанийн зах зээлийн үнэлгээ,

P_n - n компанийн хувьцааны хаалтын ханш

Q_n - n компанийн олон нийтэд чөлөөтэй арилжих хувьцааны тоо, ширхэг

w_n - n компанийн нийт ЗЗҮ-д эзлэх хувь

3.3.2 Хэрэв ямар нэгэн компанийн ЗЗҮ (w_n үзүүлэлт) нь сагсан дахь компанийн ЗЗҮ-ний 15%-иас их байвал тухайн компанийн ЗЗҮ нь тэгшитгэгдэж (4) томъёогоор тооцогдсон үзүүлэлтийг олгоно.

$$(4) \quad \text{Cap} = \frac{0.15 * \sum \text{Cap}_n}{1 - (p-s) * 0.15}$$

Cap - ЗЗҮ нь 15 хувиас хэтэрч буй ХК-ийн ЗЗҮ-ний шинэ үзүүлэлт,

$\sum \text{Cap}_n$ - Индексийн багцад орсон, ЗЗҮ нь 15 хувь хүрэхгүй байгаа компаниудын нийт үнэлгээ,

p - Индексийн багц бүрдүүлж буй ХК-ийн тоо

s - ЗЗҮ нь 15 хувь хүрэхгүй байгаа ХК-ийн тоо

3.3.3 Дээрх компанийн нийт ЗЗҮ-нд эзлэх жингийн коэффициентийг олно.

$$W_n = \frac{\text{Cap}}{\text{Cap}_n}$$

3.3.4 15 хувийн хязгаарт хамаарч, ЗЗҮ нь тэгшитгэгдсэн ХК-иудын жингийн коэффициент нь W_n байх бөгөөд бусад, дээрх хязгаарт хамаарагдаагүй ХК-иудын хувьд жингийн коэффициент нь 1,0000 гэж ойлгоно.

3.4 Индексийг дараах суурь томъёогоор тооцно.

$$\text{INDEX}_{today} = \frac{\sum (IQ_n * P_n * Adj_n)}{\text{Divisor}} * \text{Base Value}$$

INDEX_{today} – Тухайн өдрийн индекс

IQ_n – Тухайн хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг буюу Issued quantity

P_n – Тухайн хувьцаат компанийн энгийн хувьцааны тухайн өдрийн хаалтын ханш буюу Price

Adj_n – Тохируулах коэффициент буюу Adjustment factor (Adj)

Divisor – Хуваагч

Base value – Суурь нэгж

3.5 Индексийн багцад орсон аливаа хувьцаат компанийн зүгээс хэрэгжүүлсэн дараах үйл ажиллагааны дараа Хуваагчид зохих өөрчлөлтийг тусгана. Үүнд:

- 3.5.1 Энгийн хувьцаа хуваах,
- 3.5.2 Энгийн хувьцаа нийлүүлэх,
- 3.5.3 Нэмж энгийн хувьцаа гаргах,
- 3.5.4 Өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авах
- 3.5.5 Индексийн шинэ багц тодорхойлох.
- 3.5.6 Шинээр бүртгэгдсэн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх
- 3.5.7 Үнэт цаас нэмэгдэх, хасагдах

Дээрх бүх тохиолдолд олон нийтэд чөлөөтэй арилжих үнэт цаасны тоо ширхэгт өөрчлөлт орох тул Шинэ хуваагч буюу *New Divisor*-ийг дараах томъёогоор олно:

$$NewDivisor = \frac{\sum NewFreeFloat \times Divisor}{\sum OldFreeFloat}$$

3.6 ТОП-20 индексийг бодох суурь нэгж нь 19,558.19 гэсэн тогтмол нэгж, нэгдсэн индексийг бодох суурь нэгж нь 1,000 нэгж байна.

Дөрөв. БУСАД

- 4.1 Индексийн мэдээг үнэт цаасны арилжааны өдөр бүр олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.
- 4.2 Индексийг мэдээлэхдээ тухайн өдрийн индексийн үзүүлэлтийг өмнөх өдрийн үзүүлэлттэй харьцуулна. Хэрэв өссөн тохиолдолд нэмэх (+) тэмдэг, буурсан тохиолдолд хасах (-) тэмдгийг тус тус нэгжийн өмнө тэмдэглэн үзүүлнэ.
- 4.3 Бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны тоо ширхэгт өөрчлөлт орох тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолыг үндэслэн МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гарсан тухай бүр индексийг шинэчилж байна. Ингэхдээ энэ журмын 3.5 дугаар зүйлд заасны дагуу Хуваагчийг шинэчлэн тооцно.
- 4.4 Индексийн өгөгдөлд өөрчлөлт оруулах, сагсыг шинэчлэх ажлыг МХБ-ийн Арилжааны алба нь Мэдээлэл технологийн албатай хамтран цаг алдалгүй гүйцэтгэнэ.
